

Сурагчийн ирцийн мэдэгдэл – утсан орчуулгын үйлчилгээ

Сурагчийн нэр
Name of student

Хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа

Хавсаргасан захидалд таны хүүхдийн хичээлийн ирцтэй холбоотой бидний санаа зовж буй асуудлуудыг тусгасан болно.

NSW муж улсын Боловсролын тухай 1990 оны хууль нь эцэг эх/асран хамгаалагчаас тухайн хүүхэд өвчтэй эсвэл захирал өөр шалтгаанаар чөлөө авахыг зөвшөөрөөгүй бол сургууль хичээллэж буй өдөр бүр сургуульд ирж хичээллэхийг шаарддаг. Хэрэв таны хүүхэд хичээлд ирээгүй бол тус өдрөөс хойш 7 хоногийн дотор та тайлбар өгөх шаардлагатай.

Хэрэв танд хавсаргасан захидлыг ойлгоход хүндрэлтэй байгаа бол бидэнтэй холбоо барина уу. Бид танд энэ тал дээр дэмжлэг үзүүлэх боломжтой.

Хэрэв бидэнтэй холбогдоход орчуулагчийн тусламж хэрэгтэй бол 131 450 утсаар холбогдож өөрийн хэлээр орчуулагч хүснэ үү. Оператортой холбогдож холбогдохыг хүсч буй утасны дугаараа хэлвэл шугаманд орчуулагч оруулан таны ярианд туслах болно. Энэ нь үнэ төлбөргүй үйлчилгээ юм.

Сургуулийн холбогдох ажилтны нэр
Name of school contact person

Сургуулийн холбогдох ажилтны утасны дугаар
School contact person phone number